



**Монгол Улсын
Үндэсний аудитын газрын
гүйцэтгэлийн аудитын тогтолцоо
болон үйл ажиллагаанд хийсэн
Түншийн үнэлгээний тайлан**

2010 оны 11 дүгээр сар





Гарчиг

1. Түншийн үнэлгээний зорилго	3
2. Түншийн үнэлгээний үйл явц	3
3. Үндсэн мэдээлэл	5
4. Үнэлгээний дүн	6
5. Санал болгох зүйлс	8
6. Голлох асуудлууд	9
Хараат бус байдал болон бүрэн эрхийн тухайд	9
Удирдлага болон мэдлэг чадвар	10
Стратегийн болон жилийн төлөвлөлт	11
Аудитын үйл явц	11
Чанарын баталгаажуулалт болон хяналт	13
Сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудтай тогтоосон харилцаа	13
Хэвлэл мэдээлэл/олон нийттэй тогтоосон харилцаа	14
УИХ-д үйлчилгээ үзүүлэх, нийгмийн үнэт зүйлст хувь нэмэр оруулах	14
Хавсралт	15

1. Түншийн үнэлгээний зорилго

Монгол Улсын Үндэсний аудитын газар (МУҮАГ) өөрийн гүйцэтгэлийн аудитын зохион байгуулалт болон үйл ажиллагаандаа хөндлөнгийн үнэлгээ хийлгэх хүсэлт гаргасан болно.

Түншийн үнэлгээ (ТҮ)-ний гол зорилго нь МУҮАГ-ын гүйцэтгэлийн аудитын үйл ажиллагаа олон улсын сайн туршлагад нийцэж байгаа эсэхийг, түүнчлэн тус байгууллага нь улс, нийгэмд ашиг тус өгч байгааг, өөрөөр хэлбэл төр, засгийн үйл ажиллагааны талаархи хараат бус, бодитой, найдвартай, ашиг тустай мэдээллээр Улсын Их Хурал (УИХ)-ыг хангаж чадаж байгаа эсэхийг үнэлэхэд оршиж байв.

ТҮ-ээр дараахь асуудлыг шалгаж үзлээ. Үүнд:

- Хараат бус байдал, чиг үүрэг
- Менежмент, мэдлэг чадвар, төлөвлөлт

- Аудитын үйл явц, чанарын хяналт, бусад байгууллагатай харилцах харилцаа
- УИХ-д үзүүлэх үйлчилгээ, нийгэмд өгч буй ашиг тус

ТҮ-нд ашигласан асуултын жагсаалтыг Хавсралтаар харууллаа.

Энэхүү ТҮ-ний хамрах хүрээ нь МУҮАГ-ын гүйцэтгэлийн аудиттай холбоотой тогтолцоо, үйл ажиллагаагаар хязгаарлагдсан болно. ТҮ-нд аймаг, нийслэлийн аудитын газруудыг хамруулаагүй.

ТҮ нь 2011 оноос хэрэгжиж эхлэх МУҮАГ-ын стратегийн төлөвлөгөөнд зохих хэмжээгээр тус нэмэр болох тул тодорхой цаг хугацаанд дуусгах шаардлагатай болсон.

2. Түншийн үнэлгээний үйл явц

Энэхүү ТҮ Норвеги Улсын Ерөнхий аудиторов газар (НУЕАГ)-ын дэмжлэгтэйгээр МУҮАГ-т хэрэгжиж байгаа “Удирдлагын хөгжил” төслийн хүрээнд хийгдсэн болно. Үнэлгээг НУЕАГ-ын дэмжлэгтэйгээр Швед Улсын Үндэсний аудитын газар ахлан гүйцэтгэлээ.

ТҮ-ний баг (ТҮБ) үнэлгээ хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага (АДБОУБ буюу INTOSAI)-ын Түншийн үнэлгээний зааварчилгааг¹ баримталсан болно. ТҮБ МУҮАГ-аас гаргаж өгсөн баримт, материалыг шалгаж, МУҮАГ-ын удирдлага, ажилтнууд, мөн түүнчлэн УИХ, шалгагдагч байгууллага болон сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөлтэй ярилцлага хийлээ.

МУҮАГ гүйцэтгэлийн аудитыг хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгах зорилгоор 2009 болон 2010 онд гүйцэтгэсэн дараахь 3 аудитыг сонгож авлаа. Үүнд:

- Ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал болон орон нутгийн ээлжит сонгуульд зориулсан төсвийн хөрөнгийн зарцуулалт
- Боловсролын салбарын төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн үр нөлөөт байдал

Гүйцэтгэлийн аудитад баримталж буй одоогийн стандартыг илтгэн харуулах боломжтой гэж дээрх 3 аудитыг сонгосон болно. Тэдгээрийг тус тусад нь авч үзэж, дүгнэсэнгүй, харин ярилцлагаас олж авсан мэдээлэлтэй нэгтгэн, үнэлгээ хийх үндэслэл болгож ашиглалаа.

ТҮБ англи хэл дээр ажлаа явуулсан тул ТҮ-нд зориулан нэлээд тооны баримт, материалыг монгол хэлнээс орчуулах ажил хийгдсэн болно. Ихэнх ярилцлагад монгол хэлнээс англи хэл рүү, англи хэлнээс монгол хэл рүү шууд хөрвүүлэн орчуулахад гадны орчуулагчийн туслалцаа авсан. Энэ нь тодорхой бэрхшээл учруулж байснаас гадна буруу орчуулах, буруу ойлголцох эрсдэлийг дагуулж байсан. Иймэрхүү эрсдэлийг багасгах зорилгоор тайланг харилцан зөвшилцөх горимын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлангийн энэхүү эцсийн хувилбар нь МУҮАГ болон ТҮБ-аар харилцан зөвшөөрөгдсөн болно.

ТҮ-ний үйл явцыг 2010 оны зун эхлүүлсэн. ТҮБ объект дээрх ажлыг 2010 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо нэг долоо хоногийн хугацаатай хэрэгжүүлсэн бөгөөд үнэлгээний ажил энэхүү тайлангаар өндөрлөж байна.

1 АДБОУС 3100-ийн Хавсралт





Гүйцэтгэлийн аудит гэж юу вэ?²

Гүйцэтгэлийн аудит нь төрийн байгууллагын үйл ажиллагаа, хөтөлбөр буюу зохион байгуулалтад арвич хямгач байх, үр ашигтай ба үр нөлөөтэй байх гэсэн зарчмуудаас ядаж нэгийг нь хэрэгжүүлж байгаа байдлыг хараат бусаар, бодитойгоор шалгаж, улмаар түүнийг сайжруулах зорилгыг агуулдаг. Гүйцэтгэлийн аудитыг залан чиглүүлдэг гол зарчмуудыг дараахь байдлаар товч тодорхойлж болно. Үүнд:

- **АРВИЧ ХЯМГАЧ БАЙХ** зарчим нь зардлыг аль болох бага байлгах тухай ойлголт юм. Энэ нь шалгагдагч байгууллага үйл ажиллагаандаа зарцуулах нөөцийг тогтоосон хугацаанд, зохистой чанар болон тоо хэмжээгээр хамгийн тохиромжтой үнээр бэлтгэж, бэлэн байлгахыг шаарддаг.
- **ҮР АШИГТАЙ БАЙХ** зарчим нь бэлэн нөөцийг хамгийн тохиромжтой байдлаар ашиглах тухай асуудал юм. Энэ нь бүрдүүлсэн нөөц, тодорхойлсон нөхцөл байдал, бий болсон үр дүнгийн хоорондын харилцаа нь гарц болон/эсвэл биелэлтийн тоо хэмжээ, чанар, цаг хугацааны үүднээс авч үзэхэд хамгийн боломжит хэмжээнд хүрэх тухай ойлголтыг агуулдаг.
- **ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙХ** зарчим нь дэвшүүлсэн зорилтыг хангахтай холбоотой асуудал юм. Энэ нь тогтоосон тодорхой зорилго, зорилтуудыг хангах болон/эсвэл зорьж буй үр дүнг бий болгохтой холбоотой ойлголтыг агуулдаг.

Гүйцэтгэлийн аудит гэж төрийн үйлчилгээ буюу төр засгаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж үнэлэх үйл ажиллагааг хэлнэ. Энэ нь дүн шинжилгээний болон бүтээлчээр сэтгэх үр чадварыг ихээхэн шаарддаг мэдээлэлд суурилсан үйл ажиллагаа юм. Санхүүгийн аудиттай харьцуулбал гүйцэтгэлийн аудит нь данс бүртгэлээс илүүтэй үйл ажиллагаанд чиглэнэ. Түүнчлэн нийцлийн аудиттай харьцуулбал гол төлөв төр засгаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг төлөвлөсөн зорилготой, түүнчлэн арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөний талаархи зарчмуудтай тус тус уялдаж байдгаараа онцлог юм. Гүйцэтгэлийн аудитаар дараахь үндсэн асуултуудыг дэвшүүлдэг. Үүнд:

- Зөв зүйл хийж байна уу?
- Хэрэв тийм бол тэдгээрийг зөв арга замаар хийж байна уу?
- Хэрэв үгүй бол ямар учир шалтгаан байна вэ?

Түүнчлэн тэдгээр аудитын шалгах асуудал болон шалгагдагч байгууллага харилцан өөр байдаг. Тухайлбал, яамдыг тусгайлан шалгахын зэрэгцээ Засгийн газрын хөтөлбөр, үйл ажиллагааг хамруулах боломжтой. Гүйцэтгэлийн ба санхүүгийн аудитын голлох зарим ялгааг дараахь хүснэгтэд тоймлон харууллаа.

Хүчин зүйл	Гүйцэтгэлийн аудит	Санхүүгийн аудит
Зорилго	Төр засгийн үйл ажиллагаа, эсвэл авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь арвилан хэмнэх, үр ашигтай байх, үр нөлөөтэй байх зарчмын дагуу хэрэгжсэн эсэхийг үнэлэх.	Санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжсэн эсэхийг, мөн данс бүртгэл, санхүүгийн тайлагнал нь үнэн, зөв, өөрөөр хэлбэл найдвартай эсэхийг үнэлэх.
Онилох асуудал	Бодлого, хөтөлбөр, зохион байгуулалт, үйл ажиллагаа болон удирдлагын тогтолцоо.	Санхүүгийн ажил гүйлгээ, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангууд болон голлох хяналтын горимууд.
Мэргэжлийн боловсрол ба туршлага	Эдийн засаг, улс төр судлал, нийгэм судлал зэргээр мэргэшсэн байх. Мэргэжлийн хяналт шалгалтын буюу үнэлгээний ажлын туршлагатай, нийгмийн шинжлэх ухаанд ашиглагддаг арга хандлагууд болон холбогдох бусад арга/үр чадварыг эзэмшсэн байх.	Нягтлан бодох бүртгэл болон хуулийн мэргэжилтэй байх. Аудитын мэргэжлийн үр чадвар эзэмшсэн байх.
Арга хандлага	Аудитаас аудитад харилцан адилгүй байдаг.	Стандартчилагдсан хэлбэртэй.
Аудитын шалгуур	Аудиторуудад шүүн тунгаалт хийх бололцоо нээлттэй. Аудит тус бүр нь өөрийн өвөрмөц шалгууртай байдаг.	Аудиторуудад шүүн тунгаалт хийх бололцоо бага. Бүхий л аудитад хууль тогтоомж, журмаар тогтоосон стандартчилагдсан шалгуур тавигдана.
Тайлан	Асуудал бүрт тохируулан тухайлсан тусгай тайлан бэлтгэдэг. Аудитын зорилтоос шалтгаалан тайлангийн бүтэц, агуулга нь харилцан адилгүй байж болно.	Жил бүр гаргадаг санал дүгнэлт болон/эсвэл тайлан байдаг. Тодорхой хэмжээгээр стандартчилагдсан.

2 АДБОУС 3100-ийн Хавсралт

3. Үндсэн мэдээлэл

Түүхэн замнал

Монгол улсад Төрийн хяналт шалгалтын түүх 90 жилийн тэртээгээс эхлэлтэй. УИХ 2003 оны 1 дүгээр сард Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийг батлан гаргаснаар өнөөгийн МУҮАГ үүсэн байгуулагджээ. МУҮАГ нь 1995 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн Төрийн хянан шалгах хорооны гүйцэтгэж байсан ажлыг тэр үеийн ажилтнуудаар үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.

МУҮАГ 2003 оноос гүйцэтгэлийн аудит хийх хууль ёсны бүрэн эрхтэй болжээ. Дээрх хууль батлагдахаас өмнө хяналт шалгалт, аудит хийхдээ материаллаг байдлыг бараг харгалздаггүй байсан бөгөөд цөөн хэдэн стандарт, зааварчилгаатай байжээ.

Харин 2003 оноос үйл ажиллагаа нь маш их эрчимжиж байна. МУҮАГ олон улсын хэд хэдэн стандарт, журмыг монгол хэл рүү хөрвүүлж, гүйцэтгэлийн аудитын талаар гарын авлага, журам заавар боловсруулж, сургалт явуулжээ.

Ийн хөгжихийн тулд МУҮАГ хэд хэдэн байгууллагаас тусламж, дэмжлэг авч иржээ. Герман улсын Техникийн хамтын ажиллагаа (GTZ) байгууллагаас арвилан хэмнэлтийн аудит, үр ашгийн аудиттай холбоотой туслалцаа үзүүлж, мөн тоног төхөөрөмжөөр хангаж, Монгол болон Герман улсад сургалт зохион байгуулсан байна. ИБУИНВУ-ын Үндэсний аудитын газар гүйцэтгэлийн аудитын гарын авлага боловсруулахад нь тусалж, сургалт зохион байгуулах, аудитын ажлыг удирдан явуулах зэрэг хэлбэрээр туслалцаа үзүүлсэн байна. АНУ-ын Төрийн хариуцлагын газар ажилтнуудыг нь олон улсын сургалтад хамруулжээ. МУҮАГ АДБОУБ-ын Хөгжлийн санаачлагатай хамтран ажилладаг бөгөөд зохион байгуулсан сургалтад ажилтнуудыг тухай бүр оролцуулдаг байна. Хамгийн сүүлд НУЕАГ гүйцэтгэлийн аудитын удирдлагын чиглэлээр сургалт семинар явуулах байдлаар туслалцаа үзүүлжээ.

Эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуульд Төрийн аудитын тогтолцоог бүхэлд нь тодорхойлж өгсөн. МУҮАГ нь Монгол Улсын Аудитын дээд байгууллага юм. МУҮАГ аймаг, нийслэлийн аудитын газруудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангадаг. МУҮАГ УИХ-аас бусад төрийн бүх байгууллагуудад санхүүжилтийн эх үүсвэрийг нь үл харгалзан санхүүгийн болон гүйцэтгэлийн аудит хийх эрхтэй. Төрийн аудитын тухай хуульд энэ тухай "Гүйцэтгэлийн аудит нь шалгагдаж буй байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн нөөцийг хэрхэн арвич хямгач, үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй ашиглаж байгааг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гаргана"³ гэж заасан байдаг.

Эрхэм зорилго

МУҮАГ-ын 2007-2010 оны Стратегийн төлөвлөгөөнд тус байгууллага эрхэм зорилгоо "Төрийн эрх барих дээд байгууллагын үүргээ хэрэгжүүлэхэд нь Улсын Их Хуралд дэмжлэг үзүүлж, эх орон, ард түмний эрх ашгийн төлөө Засгийн газрын хүлээх хариуцлага, үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд тусална" хэмээн тодорхойлжээ.

Зохион байгуулалт, хүн хүч


МУҮАГ-ын бүтэц, зохион байгуулалтыг 2009 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар Схем 1-д харууллаа. Тус газар нь санхүүгийн ба гүйцэтгэлийн аудитын газруудад хуваагдсан зохион байгуулалтыг 2009 оны намраас эхлүүлжээ. Тэр хүртэл санхүүгийн ба гүйцэтгэлийн аудитыг аль алиныг хийдэг хоёр аудитын газартай байсан бөгөөд аудиторуд нь тэдгээр аудитыг өөр өөр хугацаанд гүйцэтгэдэг байжээ.

Ингэж төрөлжүүлэн ангилсан аудитын газруудыг боловсон хүчнээр хангахын тулд мэргэшсэн нягтлан бодогчдыг Санхүүгийн аудитын газарт шилжүүлсэн байна. МУҮАГ нийт 50 ажилтантай бөгөөд тэдний 18 нь Гүйцэтгэлийн аудитын газарт ажиллаж байна. Гүйцэтгэлийн аудитын газрын удирдах албан тушаалтнууд болон ажилтнууд нь бүгд аудит, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, санхүүгийн мэргэжилтэй бөгөөд нийгмийн ухааны чиглэлээр мэргэшсэн нэг ч хүн байхгүй байна. Гурван багийн ахлагчид бүгд мэргэшсэн нягтлан бодогчид ажээ.

3 Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, 2003, 5.1-р зүйл



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН БҮТЭЦ



4. Үнэлгээний дүн

Хараат бус байдал болон бүрэн эрх
Санхүүжилтийн эх үүсвэрийг нь үл харгалзан төрийн бүх байгууллагуудад бүх төрлийн аудит хийх бүрэн эрх бүхий хараат бус байгууллага гэсэн эрх зүйн статустай тус байгууллагын институцийн тогтолцоо нь үндсэндээ боломжийн түвшинд байна. Харин олон улсын стандартыг бүрэн төгс дагаж мөрдөхийн тулд дараахь хэдэн асуудлыг шийдвэрлүүлэх нь зүйтэй. Үүнд: Тус байгууллагын статусыг үндсэн хуулиар баталгаажуулаагүй, мөн МУУАГ нь төсвийн хувьд засгийн газраас бүрэн хараат бус байх эрх баталгаажихгүй байна.

Менежмент, мэдлэг чадвар болон төлөвлөлт

МУУАГ-ын үйл ажиллагааг үнэлэхийн тулд тус байгууллага гүйцэтгэлийн аудит хийх хууль ёсны эрхтэй болсноос хойш арав хүрэхгүй жил өнгөрсөн, мөн гүйцэтгэлийн аудитыг дагнан хийх газар бий болсноос хойш жил хүрэхгүй хугацаа өнгөрөөд байгаа гэдгийг харгалзах шаардлагатай. Гүйцэтгэлийн аудитаар төрөлжсөн газрыг тусгайлан байгуулсан нь хэдийн өөрчлөлтөд хүргэсэн нь ТҮБ-т тодорхой харагдсан билээ. Энэ нь МУУАГ-т гүйцэтгэлийн аудитын чиг үүргийг мэргэжлийн түвшинд тогтвортой хэрэгжүүлэх нөхцөл бололцоог нэмэгдүүлжээ.

МУУАГ гадаадын бусад улс орнуудын аудитын дээд байгууллагуудын дэмжлэг, удирдамжийг хүлээн авдаг, нээлттэй ханддаг ажээ. Тус байгууллага цаашид хөгжих хүсэл, сонирхолтой нь илт мэдэгдэж

байна. Байгууллагын удирдлага нь аудитын үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог бөгөөд гүйцэтгэлийн аудитыг цаашид сайжруулахад ач холбогдол өгч иржээ. МУУАГ тогтолцооны түвшинд бодлого, журам, заавруудыг бий болгоход гайхмаар сайн ажилласан байна. Харин одоо журам заавар, боловсруулалтыг бага анхаарч, практик хэрэгжилтийг сайжруулах, мэргэжлийн чиглэлээрээ хөгжих асуудалд илүү ач холбогдол өгөх нь зүйтэй юм.

Өнөөгийн удирдах албан тушаалтнууд болон ажилтнууд нь гүйцэтгэлийн аудитын бус, харин ихэвчлэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн аудитын чиглэлийн мэдлэг чадвартай мэргэжилтнүүд байна. Энэ байдал гүйцэтгэлийн аудит хийхэд шууд нөлөөлж байгаа нь харагдаж байна. Гүйцэтгэлийн аудитад одоо ч гэсэн санхүүгийн болон нийцлийн аудитын нөлөө маш их байна. Энэ нь шийдвэрлэвэл зохих асуудал бөгөөд цаашид МУУАГ гүйцэтгэлийн аудит хийхэд шаардагдах тусгайлан мэдлэг чадварыг хөгжүүлэх, шинэ ажилтнуудыг ажилд авахад тодорхой бэрхшээлтэй тулгарах болов уу гэж үзэж байна. МУУАГ төрөл бүрийн чиглэлээр академик боловсрол эзэмшсэн, зөв зан төлөвтэй, оюуны сэтгэлгээ сайтай, холбогдох чиглэлээр судалгааны ажлын туршлагатай хүнийг ажилд авахын тулд өнөөгийн боловсон хүчний бодлого, шинээр ажилд авах дүрэм журмаа эргэж авч үзэх хэрэгтэй байна.

Стратегийн төлөвлөгөө МУУАГ-ын цаашдын хөгжилд туйлын чухал ач холбогдолтой

хэрэгсэл мөн. Одоогийн стратегийн төлөвлөгөө нь гүйцэтгэлийн аудитыг хөгжүүлэхэд нэн чухал хувь нэмэр оруулсан хэдий ч байгууллага тус төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлэх бололцоогүй байжээ. Үүнийг төлөвлөгөөг дэлгэрүүлж, нарийвчлан задалсантай холбоотой гэхээсээ илүү төлөвлөгөөг тодотгож буй дүн шинжилгээний хандлага, арга хэмжээнүүдийг Бодлогын газар болон Аудитын газруудын хооронд хуваан оногдуулсантай холбон тайлбарлаж болох юм.

Аудитын үйл явц, чанарын хяналт, гадаад харилцаа

МУҮАГ гүйцэтгэлийн аудитын чиглэлээр багц стандарт, зааврууд боловсруулсан хэдий ч тэдгээр нь бүрэн хэрэгжээгүй байна. ТҮБ-ийн үзсэнээр энэ нь дотоод сургалт хийх, ажлын байранд дагалдуулан сургах чадавхи сул, удирдах албан тушаалын ажилтнууд болон ажилтнуудын мэдлэг чадвар хангалтгүй, хуучин зуршил, хандлага амь бөх байгаагаас шалтгаалж байна.

Өнгөрсөн хугацаанд гүйцэтгэж ирсэн аудитын ихэнх нь зөвхөн жижиг сажиг асуудалтай холбогдож байжээ. Аудитыг гүйцэтгэхэд оноосон хугацаа бага байдаг нь шийдвэрлэвэл зохих өргөн хүрээтэй асуудлыг хамруулах, асуудлыг тайлбарлах буюу өргөн хүрээнд харахад чиглэсэн дүн шинжилгээний арга хандлагыг хэрэгжүүлэх бололцоог бүрдүүлдэггүй гэж үзэв. Энэ байдлыг тогтолцооны хүчин зүйлс мөн гүйцэтгэлийн аудитын туршлага хангалтгүй байгаатай голчлон холбон тайлбарлаж болох юм.

Аудитын тайлангийн хувьд мөн л ийм асуудал ажиглагдаж байна. Гадны уншигчийн хувьд тайланг уншиж, ойлгоход хүндрэлтэй, түүнчлэн тайлангууд уншигчид чиглээгүй, тодорхойгүй бүтэцтэй байна. Тайлангууд нь ач холбогдолгүй, ойлгомжгүй, жижиг сажиг мэдээллээр дүүрсэн мөртлөө тэднийгээ тайлбарлаагүй, эсвэл огт уялдаа, хамааралгүй байх нь түгээмэл тааралдлаа. Хамрах хүрээ нь байнга хязгаарлагдсан байхаас гадна тайланд авч үзсэн асуудлын нарийн төвөгтэй байдлыг тусгахгүй байгаа нь олонтаа ажиглагдсан.

ТҮБ-ийн үзсэнээр тайлангууд дахь бичвэр хэсгүүд нь учир шалтгааныг хангалттай илэрхийлээгүй байна. Нарийвчилсан дүн шинжилгээ болон маргаантай асуудлыг тэнцвэртэй илэрхийлэхгүй байна. Мэдээлэл нь төдийлэн өргөн хүрээг хамарч чадахгүй байна. Хатуу чанд дүрэм, журам, ил тод байдал хангалтгүй байх, үйлчилгээний чанар гэх зэргээр буюу үр ашиг, зорилго, зорилтын биелэлтийг сайжруулахад юу хийвэл зохилтой талаар сонирхогч талуудын санал бодлыг тайланд ховорхон тусгадаг байна. Энэ нь дүн шинжилгээг

сайтар хийж, учир холбоосыг илүү өргөн хүрээтэй сэтгэхэд түвэгтэй болгоно. Учир холбоосыг тодруулж харуулснаар шалгагдагч тал чухам юу хийх хэрэгтэйг олж мэдэхэд хялбар болгодог.

Аудитын явцад шалгагдагч талын бичгээр бус, амаар илэрхийлсэн байр суурь, маргаантай асуудлыг тэр бүр харгалзан үздэггүй, тайлбар өгдөггүй, түүнчлэн тайланд тусгадаггүй болохыг ТҮБ хийсэн ярилцлагаасаа олж мэдсэн.


МУҮАГ сургалт, эрдэм шинжилгээний байгууллагууд буюу мэдлэг бүтээгч институтуудтэй нягт хамтын ажиллагааг хөгжүүлээгүй байна. Сургалт хийх, чанарын хяналтын туслалцаа авах болон холбогдох чиглэлээр мэргэжилтэн, шинжээчдийн дэмжлэг авах асуудлаар тогтолцооны зохицуулалт, арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна. Энэ байдал аудитын илрүүлэлтийн чанар, дүн шинжилгээ хийх, аудитын тайлангийн дүгнэлт боловсруулахад нөлөөлж иржээ гэдэгт ТҮБ итгэлтэй байна.

УИХ-д үзүүлж буй туслалцаа, улс, нийгэмд оруулж буй ач тус

МУҮАГ-ын гүйцэтгэлийн аудитын зорилтууд нь ихэвчлэн хууль тогтоомжийн хэрэгжилтэд чиглэж иржээ. Аудитаар үр ашиг болон үр нөлөөтэй байдлыг барагтай авч үздэггүй байна. Түүнчлэн дүн шинжилгээний хамрах хүрээ ч ихэнхдээ хязгаарлагдмал байдаг ажээ. Асуудлын бодит учир шалтгааныг барагтай бол шалгадаггүй, асуудал зохисгүй үйл ажиллагаанаас бус харин тогтоосон тогтолцооны буюу зохицуулалтын механизмын хангалтгүй байдлаас шалтгаалсан нөхцөлд ч тухайн журам, зохицуулалтыг нягталж үздэггүй байна.

УИХ-ын гишүүдтэй хийсэн ярилцлагын үед тэд МУҮАГ-ыг Засгийн газрын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээний үр дүнтэй холбоотой асуудлын учир шалтгаанд дүн шинжилгээ хийхэд илүү ач холбогдол өгөх замаар болон УИХ-д шаардлагатай өргөн хүрээний асуудалд илүү ач холбогдол өгөх замаар гүйцэтгэлийн аудитыг илүү өндөр түвшинд хүргээсэй гэж УИХ хүлээж байгаа талаар ярьж байсан юм. Ингэснээр төр, засгийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, төрийн захиргааны албыг илүү үр ашигтай, иргэдэд илүү сайн үйлчилгээ хүргэх боломжийг бүрдүүлэхэд нь шаардагдах мэдээллээр УИХ-ыг хангаж байх МУҮАГ-ын чадавхи, бололцоо дээшлэх юм.

УИХ-ын зүгээс МУҮАГ-ын үйл ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгч байгаа нь гүйцэтгэлийн аудитыг илүү их нөөцөөр дэмжих хүсэл сонирхлын дохио байж болох юм. Энэ нь тус байгууллагын цаашдын хөгжлийг урагшлуулах сайн эхлэл болно.



5. Санал болгох зүйлс

ТҮБ үнэлгээ хийх явцдаа цаашид сайжруулах шаардлагатай хэд хэдэн асуудлыг тодорхойлсон болно. МУҮАГ үйл ажиллагаагаа сайжруулахын тулд дараахь асуудлыг харгалзан үзэхийг санал болгож байна. Үүнд:

Удирдах албан тушаалтнууд болон ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх

МУҮАГ-т гүйцэтгэлийн аудитыг хэрэгжүүлэх хангалттай мэдлэг чадварыг бүрдүүлж, тогтвортой хөгжүүлэх үүднээс АДБОУБ-ын “Гүйцэтгэлийн аудитын тогтвортой чиг үүргийг бүрдүүлэх нь”⁴ удирдамжийг үндэслэл болгон ТҮБ-аас дараахь зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- боловсон хүчний бодлого, шинээр ажилтан авах журмаа эргэж авч үзэх,
- дүн шинжилгээ хийх ур чадвартай, улс төр судлал, социологи, статистик, түүх зэрэг чиглэлээр судалгааны ажлын сайн туршлага бүхий ажилтнуудыг ажилд авах; мөн мастерийн зэргийг ажилд авах нөхцөл болгох,
- цаашид шинээр ажилтан авах үйл явцад гүйцэтгэлийн аудитын мэдлэгтэй хүнийг татан оролцуулж байх,
- санхүүгийн аудитын газарт буцаж шилжих хүсэлт бүхий гүйцэтгэлийн аудитын газрын ажилтнуудын хүсэлтийг барагдуулах,
- багийн ахлагч болон удирдах албан тушаалтнууд гүйцэтгэлийн аудитын арга зүйн болон ажлын байранд сургаж дадлагажуулах мэдлэг чадвартай эсэхийг нягтлах,
- байгууллагын зорилтот дотоод сургалт зохион байгуулах чадавхи бүрдүүлэх талаар шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх ба мэдлэг чадвар хөгжүүлэх үйл ажиллагаандаа холбогдох сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын дэмжлэг, туслалцаа авах,
- урт хугацаанд тогтвортой хөгжих үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэлийг нь тогтмол шалгаж, хяналт шинжилгээ хийж байх.

Гүйцэтгэлийн аудитыг илүү чухал, дорвитой асуудалд чиглүүлэх

УИХ-ын хүлээлт, шаардлагыг хангаж, улс, нийгэмд илүү их үр өгөөж бий болгохын тулд МУҮАГ-т ТҮБ-аас дараахь зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- төлөвлөгөө боловсруулахдаа илүү өргөн хүрээтэй асуудалд анхаарлаа хандуулах ба аудитын ажилд иж бүрэн дүн шинжилгээ хийж байх,

- гүйцэтгэлийн аудит УИХ болон улс, нийгмийн хувьд туйлын чухал ач холбогдолтой асуудлуудад чиглэж байгаа эсэхийг нягтлах зорилгоор төлөвлөлтийн үйл явцыг сайжруулах,
- төлөвлөгөө нь бүхий л байгууллагын өмч болж (байгууллага даяараа оролцож) чадсан эсэхийг нягталж байхын зэрэгцээ түүний хэрэгжилтийг хангах горимуудыг авч хэрэгжүүлэх.

Аудитын үйл явц болон чанарын хяналтыг сайжруулах

МУҮАГ-т цаашид гүйцэтгэлийн аудитын үйл явцыг сайжруулах зорилгоор ТҮБ-аас дараахь санал зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- аудитад илүү сайн бэлтгэж, шалгах асуудлыг нарийвчлан судалж байх, шалгах асуудалтай холбоотойгоор тухайн салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, ТББ болон бусад эрх бүхий байгууллагуудаас мэдээлэл, судалгаа гаргуулах,
- зөвхөн хамгийн чухал ач холбогдол бүхий асуудалд аудитыг чиглүүлэх замаар болон судалгааны асуултыг хууль тогтоомжийн нийцэлд бага хандуулан, дүн шинжилгээнд илүү хүч чармайлт тавих замаар аудит нэг бүрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх,
- аудит нэг бүрт илүү их цаг хугацаа, нөөц зарцуулж байх. Үүнд төлөвлөлт, дүн шинжилгээ, тайлан бичилт ба чанарын хяналт гэх мэт аудитын бүхий л үе шатуудыг хамруулах,
- аудитын багуудад арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлж байх үүрэг бүхий ажилтантай болох,
- нарийн төвөгтэй аудитад гадны мэргэжилтнүүдийг зөвлөхөөр ажиллуулах,
- шалгагдагч байгууллагын гүйцэтгэх ажилтнууд, удирдах албан тушаалтнуудтай харилцах харилцаагаа сайжруулах,
- аудитын явцад онилсон бүлгийн уулзалтыг илүү системтэй арга замаар ашиглаж байх, түүнд гадны сонирхогч талуудыг урьж, аудитын анхан шатны илрүүлэлтийг хэлэлцэх боломж бүрдүүлэх,
- тайлан бүрийг санал авахаар илгээхийн өмнө гадны зөвлөх бүлэг эсвэл мэргэжилтэн/судлаачдаар хянуулах замаар чанарын баталгаажуулалтыг дээшлүүлэх.

зэрэг болно.

4 АДБОУС 3100-ийн Хавсралт

Тайланг уншигчид чиглүүлж бэлтгэх

Аудитын мэдээллийг илүү хүртээмжтэй болгоход тайланг уншигчид чиглэсэн байдлаар бэлтгэх нь чухал ач холбогдолтой. Иймээс МУҮАГ-т ТҮБ дараахь зөвлөмжийг өгч байна. Үүнд:

- уншигчид чиглэсэн, сайн бүтэцтэй тайлан хэрхэн бичих талаар ажилтнуудад сургалт зохион байгуулах, шинээр ажилтан авахдаа тэдний бичих ур чадварыг нь онцлон харгалздаг болох,
- нарийвчилсан дэлгэрэнгүй мэдээ, тоо баримтаар бичвэрийн хэсгийг дүүргэхгүй байхад анхаарах; тоон мэдээллийн агуулгыг тодруулж, тайлбарлах замаар тэдгээрийг уншигчид ойлгож мэдэхэд туслах, тоо мэдээлэл болон илрүүлэлтүүдийг нэгтгэж, дүгнэсэн байдлаар толилуулж байх, нарийвчилсан дэлгэрэнгүй мэдээ, тоо баримтыг зайлшгүй ач холбогдолтой гэж үзвэл хавсралт байдлаар харуулж байх,
- шалгаж байгаа асуудлыг тэнцвэртэй байдлаар илэрхийлж, илрүүлэлттэй холбоотойгоор шалгадагч талын байр сууринаас тайлбарлаж болох маргаантай асуудлыг шийдвэрлэж байх.

Сургалт, эрдэм шинжилгээний байгууллагатай ойр дотно харилцаа тогтоох

Гүйцэтгэлийн аудитын чанарыг сайжруулахын тулд сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудтай ойр дотно хамтран ажиллаж, нийгмийн ухааны салбарын судлаачдыг дараахь арга замаар ашиглахыг МУҮАГ-т ТҮБ-аас зөвлөж байна. Үүнд:

- төлөвлөлт болон урьдчилсан судалгааны явцад мэдээлэл олж авах эх сурвалж болгох,
- аудиттай холбоотой асуудлаар зөвлөхөөр ажиллуулах,
- аудитын үйл явц дахь чанарын баталгаажуулалтын зөвлөх бүлэг болгох,
- төрөл бүрийн сэдэв, чиглэлээр хичээл заалгах,
- боломжит нэр дэвшигчдээс гүйцэтгэлийн аудитад шинээр ажилтан авах үед мэдээллийн эх сурвалж маягаар тус тус ашиглаж байх.

6. Голлох асуудлууд

Хараат бус байдал болон бүрэн эрхийн тухайд

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулиар МУҮАГ-ын зохион байгуулалт, хууль ёсны бүрэн эрхийг тодорхойлжээ. Түүнчлэн Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор тус байгууллагын үйл ажиллагааг зохицуулдаг.

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуульд МУҮАГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой бүрэн эрхийг хуульчлан тогтоож өгчээ. МУҮАГ нь Монгол Улсын аудитын дээд байгууллага юм. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт болон орон тоог Ерөнхий аудитор батлах бөгөөд боловсон хүчнийг ажилд авах, тушаал дэвшүүлэх, ажлаас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ.⁵

Хуульд зааснаар зөвхөн Улсын Их Хурал (хууль тогтоох байгууллага) болон Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн дарга (Ерөнхийлөгч) МУҮАГ-т үүрэг даалгавар өгөх эрхтэй ажээ.⁶ Үүрэг даалгаврыг хэрхэн

хэрэгжүүлэхийг Монгол улсын Ерөнхий аудитор шийдвэрлэх бүрэн эрхтэй.⁷

Хуульд зааснаар төрийн аудитын байгууллагын ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцоо нь төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд өөрийн онцлогт тохирсон байх ёстой.⁸

МУҮАГ-ын төсвийн саналыг Сангийн яам хүлээж авдаг бөгөөд УИХ-д өргөн барихаасаа өмнө түүнийг өөрчлөх санал оруулах боломжтой. Энэ нь МУҮАГ-ын хараат бус байх зарчимд харшилж байгаагаас гадна олон улсын зөвлөмжийг зөрчиж байгаа явдал юм. Цаашилбал энэ нь МУҮАГ-ын үүрэг хариуцлага болох тус яаманд хийх аудитыг хараат бусаар явуулахад харшилж байна. МУҮАГ-ын хараат бус байдал нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулж байна.


Өнөөгийн байдлаар МУҮАГ-ын ажилтнуудын шагнал, урамшууллын тогтолцоог Монгол Улсын Ерөнхий аудитор шийдвэрлэх эрх мэдэл байхгүй байна.

5 Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, 2003, 14.1-р зүйл

6 Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, 2003, 7.2-р зүйл

7 Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, 2003, 13.4.2 болон 13.6-р зүйл

8 Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, 2003, 14.4-р зүйл



Сайн туршлага

МУҮАГ ямар асуудалд аудит хийхээ, аудитыг яаж гүйцэтгэхээ, мөн гүйцэтгэсэн аудитаа хэрхэн тайлагнахаа өөрөө бүрэн бие даан шийдэж байна. Төрийн байгууллагуудаас шаардлагатай бүх мэдээлэл, баримт бичигтэй танилцах эрх нь ч баталгаажсан байна.

Сайжруулах чиглэлүүд

Олон улсын стандартад бүрэн нийцэхийн тулд МУҮАГ нь төсөв болон ажилтнуудынхаа урамшуулалтай холбоотой асуудлаар Засгийн газраас бүрэн утгаараа хараат бус болох шаардлагатай.

Удирдлага болон мэдлэг чадвар

Гүйцэтгэлийн аудитын ажилтнуудын хувьд 2009 оноос тэдний үндсэн чиг үүрэг нь гүйцэтгэлийн аудит болжээ. Тэд аудитыг тус бүрдээ хийдэг гурван багаас бүрдсэн тусдаа газарт хуваарилагдан ажиллаж байна. Аудитын журам, стандарт, горим, арга зүйн асуудал боловсруулах үүргийг Бодлогын газар хариуцан ажиллаж байна. Арга зүйн зөвлөгөө өгөх үүрэгтэй ажилтан Гүйцэтгэлийн аудитын газарт байхгүй ажээ.

Хоёр тусдаа аудитын газруудыг зохион байгуулах үед удирдлага ажилтнуудад албан ёсоор сонголт хийх боломж олголгүйгээр шууд шинэ ажилд томилжээ. Гүйцэтгэлийн аудитын газрын удирдах болон гүйцэтгэх ажилтнуудын дунд нийгмийн ухааны чиглэлээр мэргэшсэн ганц ч хүн алга. Гүйцэтгэлийн аудитын багийн ахлагчийн үүргийг Мэргэшсэн нягтлан бодогч ажилтнуудад хариуцуулжээ.

МУҮАГ 2011 онд 15 хүнийг шинээр ажилд авах найдлагатай байгаа. Одоогоор тус байгууллага шалгагдагч байгууллагууд болон бусад эх сурвалжаас “өндөр мэдлэг чадвартай” хүмүүсийг сонгон шинээр ажилд авдаг байна. Яг одоо тус байгууллагад 50 хүн ажиллаж байгаа бөгөөд сул орон тоо байхгүй ажээ.

Ажилтнуудын ярьж байгаагаар гүйцэтгэлийн аудитад шилжиж ороход болон удаах хэдэн жилийн хугацаанд бэрхшээл их байжээ. Харин энэ хандлага сүүлдээ өөрчлөгдөж, өнөөгийн байдлаар аудиторчуудын ихэнх нь гүйцэтгэлийн аудит хийхэд чухам юу шаардлагатайг сайтар ойлгодог болжээ. Гэсэн хэдий ч тэдний дотор санхүүгийн аудитын газарт ажиллах мэдлэг чадвар, хүсэл сонирхол бүхий ажилтан цөөнгүй байна. ТҮБ ярилцлагад оролцсон шалгагдагч талын төлөөлөл аудит хангалттай үнэ цэн бий болгодоггүй - ажлын гүйцэтгэлийг сайжруулахад тус нэмэр болдоггүй болохыг мэдэгдсэн. Тэд үүнийг аудитын хамрах хүрээ

хязгаарлагдмал, хоорондын харилцаа холбоо болон дүн шинжилгээ хангалтгүй гэсэн гурван гол учир шалтгаантай холбон тайлбарлаж байсан.

Сайн туршлага

МУҮАГ-ын дээд удирдлага гүйцэтгэлийн аудитыг амжилттай хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж байна. МУҮАГ санхүүгийн аудит болон гүйцэтгэлийн аудитыг хоёр тусдаа газарт хариуцуулан зохион байгуулсан болон бодлого, журмын боловсруулалтад тэргүүлэх ач холбогдол өгч байгаа нь урагшлах зөв зүйтэй алхам болжээ. Мөн удирдлагын зүгээс гүйцэтгэлийн аудитын чанарын баталгаажуулалтын үйл явцад идэвхтэй оролцож байгаа нь ч эерэг хандлага юм.

МУҮАГ-ын удирдлага байгууллагаа хөгжүүлэх, гүйцэтгэлийн аудитын дэвшилтэт туршлагаас суралцаж, байгууллагадаа нэвтрүүлэх хүсэлтэй ажээ. Энэ бол үнэхээр чухал ач холбогдолтой бөгөөд удирдлагын сайн үйл ажиллагааг илтгэж байна. Удирдлагын ийм арга хандлага нь байгууллага хөгжих нөхцөл боломжийг дээшлүүлнэ.

Сайжруулах чиглэлүүд

Багууд болон удирдах ажилтнуудын гүйцэтгэлийн аудитын талаарх мэдлэг чадварыг цаашид улам хөгжүүлэх нь маш чухал ач холбогдолтой. Үүний тулд багуудын хөгжин сайжрах үйл явцыг, ялангуяа, гүйцэтгэлийн аудиторт шаардлагатай мэдлэг чадварыг багийн гишүүн нэг бүр нь эзэмшсэн эсэхийг, мөн түүнийг тэдэнд хэрхэн эзэмшүүлж байгааг ажиглаж, нягталж байх нь зүйтэй.

МУҮАГ шинээр ажилтан авахдаа тэдгээр нь дүн шинжилгээний өндөр ур чадвартай, холбогдох судалгааны ажлын туршлагатай эсэхийг баталгаажуулах замаар байгууллагынхаа ур чадварын баазыг өргөтгөж байх зайлшгүй шаардлагатай. Гүйцэтгэлийн аудитад хувь хүний ур чадвар онцгой чухал ач холбогдолтойд тооцогддог.

Бодлогын газар болон Гүйцэтгэлийн аудитын газрын хоорондын хамтын ажиллагаа нь цаашид сайжруулах шаардлагатай чиглэл мөн болно. Үүнийг нэг талаар стандарт болон гарын авлага боловсруулахад Гүйцэтгэлийн аудитын газарт илүү үүрэг хариуцлага ногдуулах замаар хийж болно. Өөр нэг арга зам нь гүйцэтгэлийн аудитын мэдлэг чадвар болон үйл ажиллагааг төлөвшүүлэхийн тулд гарын авлага боловсруулах үйл явцад, эсвэл холбогдох сэдвүүдээр сургалт, семинар зохион байгуулахад тус газрын ажилтнуудыг оролцуулдаг байх явдал юм.

Стратегийн болон жилийн төлөвлөлт

МУҮАГ-ын стратегийн төлөвлөгөөний хугацаа 2010 оноор дуусч байна. Энэ төлөвлөгөөнд МУҮАГ-ын чанарын удирдлагын тогтолцоо, аудитын үр дүн, дотоод мониторинг, арга зүй, арга хандлагыг аудитын үр ашиг, үр өгөөжийн хамт сайжруулах стратегийн зорилтуудыг агуулжээ. Хэдийгээр энд стратегийн хамгийн чухал асуудал бүр дээр төвлөрч чадаагүй боловч нэн гайхам, нэлээд нарийвчилсан төлөвлөгөө болжээ.

Стратегийн төлөвлөгөөнд гүйцэтгэлийн аудитын сэдэв, хүрээг гурваас доошгүй жилийн хугацаанд урьдчилан тодорхойлох тухай зааснаас гадна аудитын сэдвүүдийн нэлээд дэлгэрэнгүй жагсаалт тусгагдсан байна. Гэвч тэдгээр бүх сэдвээр аудит хийж чадаагүй байх бөгөөд жагсаалтыг дахин шинэчлээгүй ажээ.

УИХ-ын гишүүд болон бусад ажилтнуудаас авсан мэдээллээс үзвэл МУҮАГ одоо гүйцэтгэлийн аудитын жилийн төлөвлөгөө боловсруулж байгаа юм байна. Өнгөрсөн жилийн дундуур олон тооны хүсэлтүүд нэмж ирснээс болон бусад учир шалтгааны улмаас төлөвлөсөн зарим аудит хийгдэхгүй байж магадгүй. Мөн өнгөрсөн жилд гүйцэтгэлийн аудитыг сонирхох хандлага өмнөх жилүүдээс илүү нэмэгдсэн нь УИХ-ын зүгээс төлөвлөгөөт аудит дээр нэмж аудит хийх хүсэлтийг жилийн дундуур олноор ирүүлэх болсноор тайлбарлаж болно.

Сайн туршлага

Тус байгууллагын одоогийн стратеги төлөвлөгөөнд наад захын олон асуудлууд үндсэндээ тусгагдсан байх бөгөөд түүний чанарын удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх болон аудитын үр өгөөжийг тогтвортой дээшлүүлэх гэсэн хоёр гол зорилт нь ялангуяа гүйцэтгэлийн аудитын хөгжилд ихээхэн ач холбогдолтой юм.

МУҮАГ жилийн төлөвлөгөө боловсруулах асуудлаар УИХ-тай холбоотой ажилладаг ажээ. Шийдвэр гаргагчид МУҮАГ-ын тэргүүлэх ач холбогдол өгч байгаа асуудлуудыг мэдэх шаардлагатай учир энэ нь ихээхэн ач холбогдолтой. 2011 оны төлөвлөгөөний тухайд УИХ-ын Тамгын газар Байнгын хороодоос гаргаж буй гүйцэтгэлийн аудит хийлгэх саналуудтай холбоотойгоор дахиад л зохицуулагчийн үүрэг гүйцэтгэх ажээ.

Сайжруулах чиглэлүүд

Дараагийн стратегийн төлөвлөгөө нь УИХ болон нийгэмд бүхэлд нь илүү ач холбогдол бүхий аудитын сэдвүүдэд анхаарал хандуулах боломж олгож байна. Энэ нь

гүйцэтгэлийн аудитын илүү тогтвортой, дэвшилтэт үйл ажиллагааг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг дүгнэн шинжлэх сайхан боломж ч болж магадгүй.

Тус байгууллага стратегийн төлөвлөгөө боловсруулах ажилд ажилтнуудыг аль болох түлхүү татан оруулах нь өндөр ач холбогдолтой. Энэ нь тэд стратегийн хэрэгжилтэд өөриймсөг хандах, төлөвлөгөө, түүний алсын хараа, зорилгуудыг МУҮАГ-ын бүхий л түвшинд сайтар таниулан мэдүүлэх явдлыг баталгаажуулж өгнө.

Стратегийн төлөвлөгөө нь байгууллагад байнгын тасралтгүйгээр үр нөлөө үзүүлж байгааг бататгах үүднээс түүнд албан ёсоор үнэлгээ хийж байх ажлыг жилийн ажлын төлөвлөгөөний нэг хэсэг болгон тусгаж байх нь ач холбогдолтой байдаг. Энэ ажилтай зэрэгцүүлэн дараагийн жилүүдэд гүйцэтгэлийн аудит хийх асуудлын жагсаалтыг ч шинэчилж болох юм.


Жилийн төлөвлөлт, УИХ-тай тогтоосон харилцаа, зарим болзошгүй хүсэлтийн тухайд МУҮАГ нь өөрийн шударга ёсны зарчмыг чанд сахиж, зөвхөн өөрийн тэргүүлэх ач холбогдолтой асуудалд нийцсэн хүсэлтийг хүлээн авдаг байх нь зүйтэй. Тэгэхээр энэ чиглэлээр боловсронгуй болгох нэг ажил нь эдгээр асуудлуудыг ангилж зэрэглэх, ирүүлсэн саналуудыг хэрхэн шийдвэрлэх бодлого, журмыг УИХ-тай тохиролцох шаардлагатай.

Аудитын үйл явц

Гүйцэтгэлийн аудитад урьдчилсан судалгаанаас эхлээд аудитын тайланг бичиж дуусгах хүртэл гурван сарын хугацаа зарцуулжээ. Хугацаа ийнхүү богино байх нь төлөвлөлт, мэдээ баримт цуглуулах, дүн шинжилгээ хийх, мөн тайлан бичих явцад нягт нямбай хандахад сөрөг үр дагавар учруулна.

Багууд үндсэн асуудлаа судлахаас өмнө урьдчилсан судалгаа явуулж, ажлын төлөвлөгөө боловсруулна. Үндсэн судалгаанд бэлтгэхдээ багууд хамрах хүрээг нарийвчлах үүднээс дизайн матриц болон асуудлын шинжилгээний арга зүйг хослуулан хэрэглэдэг. ТҮБ-ийн зүгээс аудитын багууд нь асуудлын нарийн төвөгтэй байдлын талаар илүү сайн төсөөлөл олж авах зорилгоор судлаачид, холбогдох яамтай өргөн хүрээнд тогтвортой хамтран ажилладаггүй юм байна гэж үзлээ.

Сургалт, судалгааны байгууллагын төлөөлөл болон мэргэжилтнүүдээс бүрдсэн онилсон бүлгийн ярилцлага, хэлэлцүүлгийг гүйцэтгэлийн аудитад огт ашигладаггүй юм байна. Онилсон бүлгийн хэлэлцүүлгээр тухайн асуудлыг олон талаас нь тодотгож





чаддаг. Иймэрхүү үйл ажиллагаа нь идэвхитэй, шууд харилцаа үүсгэж, тусгаж, хүлээн авах боломжийг бий болгодог. Онилсон бүлгийн хэлэлцүүлгийг амжилттай явуулж чадвал харилцан мэдлэгээ солилцох, оролцогчдыг хөгжүүлэхэд хувь нэмэртэй байдаг.

Тайлан дахь дүн, дүгнэлтүүд нь хариулт олж авахаар төлөвлөсөн илүү өргөн хүрээний аудитын асуултуудтай нь харьцуулахад ихэнх тохиолдолд тун явцуу байна. Бидний авч үзсэн гурван тайлан дахь дүгнэлтүүд шударга буюу хангалттай, цогц дүн шинжилгээнд тулгуурласан эсэх нь цаашид анхаарвал зохих асуудал байна.

Аудиторууд болон шалгадагч байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн асуудал хариуцсан ажилтнуудын хооронд сайн харилцаа холбоо тогтжээ. Харин тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааг хариуцсан бусад ажилтнууд, дээд удирдлагатай харилцаа холбоо тааруу байх шиг санагдсан болно.

Объект дээрх шалгалт дуусмагц аудитын баг аудитын илрүүлэлтээ хэлэлцэхээр шалгадагч байгууллагыг уулзалтад урьдаг. Дараа нь тайлангийн төслийг шалгадагч байгууллагад илгээж 10 хоногийн дотор саналыг нь авна. Энэ нь аудитор болон шалгадагч талын хооронд нэгдсэн, нийтлэг ойлголцол бий болгох зорилготой.

Өнөөгийн байдлаас харахад гүйцэтгэлийн аудит дуусмагц хийгддэг Удирдлагын зөвлөлийн хурал МУҮАГ болон шалгадагч талын хоорондын харилцаанд сөргөөр нөлөөлөхөөр санагдлаа. Мөн нээлттэй байдлыг хангахааргүй байна. Хэвлэлийнхэн байгаа болохоор санал бодол, үзлээ харилцан солилцох боломж хязгаарлагдмал, ихэнхдээ маргааны хэлбэрээр явагддаг ажээ.

Сайн туршлага

Тайлан бичих явцад багууд долоо хоног тутамд хурал хийж, аудитын илрүүлэлт болон хийгдэж байгаа бусад ажлын талаар хэлэлцдэг байна. Тэд тайлан бичихдээ өөр өөр хэсгүүдээр нь хуваан хариуцдаг бөгөөд тайлангийн төслийг хэлэлцүүлэхэд удирдлагад зориулан танилцуулга бэлтгэдэг ажээ. Тайлангийн төслийг шалгадагч байгууллагад илгээхийн өмнө тодруулга хийх шаардлагатай эсэхийг Ерөнхий Аудитор болон Ерөнхий Аудиторын орлогч шийдвэрлэнэ.

Сайжруулах чиглэлүүд

Цаашид сайжруулах шаардлагатай чиглэлүүдийн нэг нь төлөвлөлт, урьдчилсан судалгаа хийж буй арга зам юм. МУҮАГ санхүүгийн үр өгөөж гаргахад хэт анхаарлаа хандуулснаас болж арай явцуу асуудлуудад төвлөрч ажилладаг

байж болзошгүй байна. Үүний улмаас өргөн утгаараа нийгэмд илүү чухал ач холбогдолтой байх магадлалтай асуудлуудад бага ач холбогдол өгч иржээ. Аудитад сайтар бэлтгэхийн тулд жилд ядаж зарим цөөн аудитад илүү их цаг хугацаа зориулах шаардлагатай байна. Бэлтгэл ажилд ихээхэн цаг хугацаа зориулсан (ном зохиол судлах, эрдэмтэд, мэргэжилтнүүдтэй ярилцах гэх мэт) аудитаас нийгэмд оруулах үнэ цэн илүү өндөр байдаг билээ.

Анхаарвал зохих өөр нэгэн асуудал нь ажлын арга барил болно. Энэ нь арга хандлага буюу судалгааны дизайныг боловсруулах ба илүү мэргэжлийн арга техникүүд, тухайлбал, хэрхэн сайн ярилцлага хийх вэ, статистикийн аргуудыг хэрхэн хэрэглэх вэ гэдгийн аль аль нь юм. Энэ нь МУҮАГ-ын зүгээс хөгжлийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж болох чиглэл юм.

Бас нэг чухал чиглэл нь шалгадагч байгууллагуудтай харилцах харилцааг сайжруулж, тэдний байр суурь, тайлбарыг сайтар харгалзаж байхтай холбоотой. Шалгадагч байгууллагын удирдлага, үйл ажиллагаа хариуцсан ажилтнуудтай харилцах харилцаагаа хөгжүүлэхийг МУҮАГ-т ТҮБ-ийн зүгээс зөвлөж байна.

Баг дотроо болон баг хооронд мэдлэг, туршлагаа хуваалцахад мөн л дэвшил гаргах хэрэгтэй. Багууд, тэрчлэн багийн зарим гишүүд нь аудитын туршид тусдаа, бие даан ажилладаг болов уу гэж санагдсан. Багийн гишүүд тус бүрдээ аудитын тодорхой нэг хэсгийг нь хариуцан ажиллах болдог тул нийт багаараа хэлэлцэх, дүн шинжилгээ хийхэд цаг хугацаа бага олддог ажээ. Түүнчлэн, аудитаас өргөн хэмжээнд сурч мэдсэн зүйлсээ дараа нь хэлэлцэхэд ч цаг хугацаа бага зориулдаг байна.

Дараагийн сайжруулах чиглэл нь аудитын тайланг хэрхэн уншигчид чиглэсэн хэлбэрээр бичих сургалттай холбоотой юм. Өнөөгийн бэлтгэсэн тайлангууд дотор уншихад хялбар нь маш цөөн байна. Янз бүрийн сэдвүүдийг холилдуулжээ. Нэг ижил тайланд томоохон боловч огт уялдаа хамааралгүй асуултуудад хариулт өгснөөс гадна илрүүлэлт нь тэдгээрийн хоорондын уялдаа, холбоонд дүн шинжилгээ хийхээс илүүтэйгээр зөвхөн тоо, баримтыг тоочин өгүүлснээр хязгаарлагдаж байна. Мөн жижиг, ач холбогдол багатай олон тооны илрүүлэлтийг тайлагнасан байх бөгөөд олон тооны дүрс, хүснэгтүүдийг толилуулсан байх юм. Аудиторууд илрүүлэлтүүдээ ангилж, нэгтгэлгүй зүгээр л бүгдийг нь тайландаа жагсаан бичсэн бололтой. Ач холбогдолтой болон ач холбогдолгүй илрүүлэлтүүдийг эн тэнцүү авч үзжээ.

МУУАГ цаашид өөрийн зөвлөмжийг болон түүний учир шалтгааныг хэрхэн илүү сайн толилуулэх вэ гэдэгт анхаарах нь зүйтэй. Хэрвээ МУУАГ өөрийн санал бодлыг шалгагдагч талаар хүлээн зөвшөөрүүлэхийг хүсч байгаа бол бүтээлч зөвлөмж өгч байх шаардлагатай юм. ТҮБ-ийн авч үзсэн гурван тайлангийн хувьд илрүүлэлт болон зөвлөмж өөр хоорондоо хэрхэн уялдаж байгааг олж харахад амаргүй байлаа.

Чанарын баталгаажуулалт болон хяналт

Гүйцэтгэлийн аудитуудын тус бүрдээ бэлтгэсэн баримт бичгийг багийн ахлагч хянадаг. Ерөнхий Аудиторын Орлогч болон Ерөнхий Аудитор гарцын чанарын эцсийн шатны баталгаажуулалт хийхийн өмнө Гүйцэтгэлийн Аудитын Газрын менежер, захирал хоёр чанарын хяналт тавина.

Гүйцэтгэлийн аудитын чанарт хийх дотоод аудитыг Бодлогын газар жил бүр гүйцэтгэдэг. Гүйцэтгэлийн аудитад жил тутам хийгдэх дотоод аудит нь дүрэм журмын нийцэлд чиглэсэн хандлагатай. Ийм маягийн чанарын хяналт нь гүйцэтгэлийн аудитуудыг хөгжүүлэхэд тус нэмэр багатайгаас гадна гүйцэтгэлийн аудитын чанарыг дээшлүүлж байгаа нь эргэлзээтэй.

Сайн туршлага

Чанарын баталгаажуулалтын үйл явцад бүх түвшний удирдлагууд оролцдог бөгөөд энэ нь гүйцэтгэлийн аудит, тайлангийн чанарыг ихээхэн сайжруулах боломжтой.

Сайжруулах шаардлагатай чиглэлүүд

Аудитын чанарын хяналтын үйл явцаа эргэж авч үзэхийг ТҮБ-ийн зүгээс МУУАГ-т зөвлөж байна. Доорх бичвэрт дурдсан алхмууд нь юу хийвэл зохилтойг тодорхойлж өгсөн болно.

Сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудтай тогтоосон харилцаа

Одоогийн байдлаар МУУАГ болон сургалт, судалгааны байгууллагуудын хооронд ямар ч хамтын ажиллагаа байхгүй байна. Өмнө нь сургалт, судалгааны байгууллагын төлөөлөгчид Төрийн Хянан Шалгах хорооны гишүүнээр ажиллаж байсан ажээ.


Сайжруулах чиглэлүүд

Цаашид сайжруулах шаардлагатай чухал чиглэлийн нэг нь төрөл бүрийн салбарын чиглэлээрх сургалт, судалгааны байгууллагатай сайн харилцаа тогтоох асуудал юм. Цаашид сургалт, мэргэжлийн туслалцаа, чанарын хяналт гэх зэрэгт байнгын хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийг бүрдүүлсэн шийдэл олохыг МУУАГ-т ТҮБ-аас зөвлөж байна.

Аудитын үйл явцын чанарыг хянах 10 чухал алхам (урьдчилсан болон үндсэн судалгаа)¹

1. Тухайн асуудлаархи ном зохиол, судалгааны материал, вэбсайтыг уншиж судлах, судлаач, шинжээч, энэ чиглэлээр ажиллаж байсан хүмүүст хандах, холбогдох яам, байгууллагуудын ажилтнуудтай ярилцах замаар аудитад сайтар бэлтгэх,
2. Аудитын төлөвлөгөөний төслийг удирдлагад танилцуулж, засвар өөрчлөлт хийгдэхээс өмнө ажилтнууд дотроо хэлэлцэх (ингэхдээ багийн гишүүн биш, туршлагатай ажилтнаар чанарын хяналт хийлгэх),
3. Батлагдсан үндсэн судалгааны зорилго, арга зүй, үйл явцыг шалгагдагч талд сайтар тайлбарлах,
4. Үндсэн судалгааны эхэнд (эсвэл урьдчилсан судалгааны шатанд) судлаачид/шинжээчдийг тухайн шалгалттай холбоотой нөөц мэргэжилтэн, мэдээ баримт шалгагч, лавлах бүлэг байдлаар оролцуулах,
5. Судалгааны дунд үед тухайн асуудалд хамааралтай сонирхогч талуудтай онилсон бүлгийн уулзалт/семинар хийж, урьдчилсан ажиглалт буюу илрүүлсэн зүйлс, авч болох арга хэмжээний санал зэргийг нууц хадгалах амлалтын дор хэлэлцүүлэх,
6. Тайлангийн төсөлд шаардлагатай бол тодорхой үнэлгээний шалгуурын дагуу чанарын дотоод хяналтыг хийлгэх (хоёрдогч түнш гэгдэх багийн гишүүн бус туршлагатай ажилтнаар),
7. Тайлангийн төслийг шалгагдагч талын саналыг авахаар илгээхээс өмнө судлаачид, шинжээчдээр хянуулах,
8. Шалгагдагч байгууллагаар баримт, мэдээллийг хянуулах, ирүүлсэн саналуудад нь баг дотроо болон аудитын менежертэй хамтран дүн шинжилгээ хийх,
9. Тайлангийн төслийг эцэслэн батлуулахаар удирдлагад гардуулах,
10. Аудитын газрын удирдлага болон шалгагдагч байгууллагууд төгсгөлийн уулзалт хийх.

1 ТҮБ-ийн туршлагад үндэслэсэн



Хэвлэл мэдээлэл/олон нийттэй тогтоосон харилцаа

Хуульд⁹ зааснаар МУҮАГ нь аль ч гүйцэтгэлийн аудитын тайланг хэвлэн нийтлүүлэх боломжтой. Хэвлэн нийтлүүлсэн тайлангийн жагсаалтыг өдөр тутмын мэдээллийн хэрэгсэл, мөн интернетэд улирал тутам байрлуулах ёстой.

Гүйцэтгэлийн аудитын тайланг хэвлэн нийтлэх нь улсын хэвшил дэх удирдлагын үйл ажиллагааны ил тод байдалд зохих хувь нэмэр оруулж буйгаас гадна гүйцэтгэлийн аудитаар дамжуулан төрийн захиргаа болон засаглалыг сайжруулахад ямар хувь нэмэртэйг¹⁰ илтгэн харуулдаг ажээ.

МУҮАГ-т гүйцэтгэлийн аудитын тайланг эцэслэн бэлтгэсний дараа түүнд олон нийтийн анхаарал, сонирхлыг татахын тулд хэвлэл мэдээллийн хэрэгслийг хэрхэн ашиглах тухайлсан стратеги байхгүй, мөн гүйцэтгэлийн аудитын тайлангаас хэвлэлд нийтлүүлэх талаар сэтгүүлчидтэй шууд харилцах явдал хангалтгүй байна. Аудитын тайлангийн төслийг Удирдах зөвлөлөөр хэлэлцэх бүрт хэвлэлийн мэдээ бэлтгэж иржээ. Улирал тутмын зар, мэдээллийг одоогоор санхүүжилт хомс гэх үндэслэлээр өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтлүүлдэггүй байна. Түүнчлэн, гүйцэтгэлийн аудитын хэвлэмэл тайланг жирийн иргэд олж авах боломж үгүй байна.

Сайн туршлага

МУҮАГ нь гүйцэтгэлийн аудитын бүх тайланг интернетэд байрлуулсан тул олж унших бололцоотой.

Сайжруулах чиглэлүүд

Хэвлэл мэдээллийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхийг МУҮАГ-т ТҮБ-ийн зүгээс зөвлөж байна. Энэ чиглэлээрх одоогийн үйл ажиллагаа нь тайланг хэвлэн нийтлэх болон олон нийтийн мэдээлэл олж авах боломжид сөргөөр нөлөөлж байна.

Хэвлэлийн товч мэдээ бэлтгэж, хэвлэлийн бага хурал зохион байгуулж байх нь зүйтэй. Эдгээр нь олон нийтийн анхаарлыг татахад хувь нэмэр оруулахаас гадна, ил тод байдал, хариуцлагыг урамшуулан дэмжихэд чухал ач холбогдолтой арга хэрэгслүүд юм. Харин аудитын тайланг эцэслэж, хэвлэн нийтлүүлэхээс өмнө хэвлэл мэдээллийнхэнд мэдээлэл олж авах боломж өгч болохгүй.

УИХ-д үйлчилгээ үзүүлэх, нийгмийн үнэт зүйлст хувь нэмэр оруулах

Хуульд¹¹ зааснаар МУҮАГ аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөө боловсруулахдаа УИХ, түүний Байнгын хороодоос ирүүлсэн саналыг харгалзан үзэх ёстой.

Ерөнхий Аудиторын зүгээс УИХ-д илгээхээр шийдвэрлэсэн тайланг нэг бол УИХ-ын Байнгын хороодод, эсвэл УИХ-ын даргад хүргүүлэх бөгөөд тайлангуудыг хэрхэн хэлэлцэх (Байнгын хороогоор уу, УИХ-ын чуулганаар уу) болон тайлангийн мөрөөр ямар арга хэмжээ авахыг тэд шийдвэрлэдэг байна.

Төсвийн байнгын хороо МУҮАГ-ын гүйцэтгэлийн аудит хийх чадавхийг бэхжүүлэх хүсэлтэй буйгаа илэрхийлжээ. УИХ-ын төлөөллүүд гүйцэтгэлийн аудитын тайлан нь бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг нягтлан шалгахад илүү чиглэж, санхүүгийн болон хууль, тогтоомжийн нийцэлтэй холбоотой асуудлыг бага анхаарахыг хүсч байна.

Сайн туршлага

УИХ-ын гишүүд МУҮАГ-ыг хянан шалгагчийн байр сууринд хүртэл хөгжиж, улмаар нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулдаг байгууллага болгох сонирхолтой байгаагаа илэрхийлж байсан. Тэд МУҮАГ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс тийм боломжийг олж харсны дүнд түүнийг цаашид улам ихээр бэхжүүлэн хөгжүүлэхийг чин сэтгэлээсээ хүсч байгаа болов уу.

Сайжруулах чиглэлүүд

МУҮАГ цаашид УИХ-тай харилцаагаа улам хөгжүүлж, гүйцэтгэлийн аудит гэж юу болох талаар УИХ-ын гишүүдэд мэдээлэл өгөхөд онцгой ач холбогдол өгч ажиллах нь тустай юм.

Гэхдээ хамгийн чухал нь гүйцэтгэлийн аудитыг улам илүү хөгжүүлж, УИХ болон улс, нийгэмд тулгамдаж байгаа илүү өргөн хүрээтэй асуудлуудыг авч үзэж байх хэрэгтэй. Үр ашигтай хөтөлбөр, удирдлагын талаарх өнөөгийн сайн жишээ нь улс төрийн ирээдүйн шийдвэр гаргах үйл явцад тус нэмэр болно.

9 Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, 2003, 22-р зүйл 10 АДБОУС 3100-ийн Хавсралтаас авав.

11 Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, 2003, 16.2-р зүйл

Хавсралт

Түншийн Үнэлгээний Багийн авч үзсэн гол асуудлууд

- i. МУҮАГ-ын гүйцэтгэлийн аудитын үйл ажиллагаа нь юунд, хэрхэн, хэзээ аудит хийх вэ гэдгийг сонгох тухайд болон аудитыг гадны зохисгүй нөлөөнөөс ангид гүйцэтгэх боломжийн үүднээс хараат бус байдал ямар хэмжээнд хангагдаж байна вэ? Гүйцэтгэлийн аудитын газарт ажилтнуудыг шилж сонгох, удирдах үнэлгээний тогтолцоо нь гадны нөлөөллөөс хир хамгаалагдсан бэ? Гүйцэтгэлийн аудитыг хэрэгжүүлэх нөөцтэй холбоотой төсвийн санал Засгийн газрын нөлөөлөлгүйгээр УИХ-д танилцуулагддаг уу?
- ii. Аудит хийх бүрэн эрхийн хүрээнд арвич хямгач, үр ашигтай, үр нөлөөтэй байдалд аудит хийх боломж бий юу?
- iii. Ажилтнууд нь ажил үүргээ алагчлалгүй, бодитой гүйцэтгэж байгаа эсэхийг МУҮАГ хэрхэн нягталдаг вэ?
- iv. Аудитын төлөвлөгөө болон авч үзэх үндсэн асуудалтай холбоотой, мөн түүнчлэн гүйцэтгэлийн аудитын бүхий л үе шатанд дотоод мониторинг хийх, хянан удирдах, гадны мэргэжилтний туслалцааг авахад удирдамж зааварчилгаагаар хангах чанарын хяналтын тогтолцоог ямар хэмжээнд хөгжүүлээд байна вэ?
- v. МУҮАГ-ын гүйцэтгэлийн аудитын үйл ажиллагаа нь тус байгууллагад мөрдөгдөж байгаа гүйцэтгэлийн аудиттай холбоотой журам, зааварчилгаа болон хяналтын тогтолцоог хэр даган мөрдөж байна вэ?
- vi. Гүйцэтгэлийн аудитын үйл явц нь хэр зохистой явагдаж байна? Гүйцэтгэлийн аудитын тайлангууд найдвартай, бодитой байж чаддаг уу?
- vii. МУҮАГ-аас хүргүүлж байгаа гүйцэтгэлийн аудитын тайлангууд нь УИХ болон Засгийн газарт хэр зэрэг ашиг тусгай мэдээлэл өгч чадаж байна вэ?

Түншийн Үнэлгээний Баг

Швед Улсын Үндэсний аудитын газар:

- Тони Англери – Багийн ахлагч

Норвеги Улсын Ерөнхий аудиторын газар:

- Ингвилд Гюлбрандсен
- Ойвинд Бэрг Ларсен

Түншийн үнэлгээний багийн орчуулагч:

- Лхагвасүрэнгийн Золзаяа

МУҮАГ-ын Дотоод түншийн үнэлгээний баг:

- Мягмарын Давааням
- Жигмэдсүрэнгийн Сарантуяа



